

АГУУЛГА

НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	3
1.1. Төслийн нэр	3
1.2. Төсөл хэрэгжүүлэх аж ахуйн нэгж байгууллага	3
1.3. Төслийн байршил, тойм зураг	3
1.4. Төслийн төлөвлөлт	5
1.5. Төсөл хэрэгжүүлэх орчны дэд бүтэц.....	5
ХОЁР.ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ – ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	6
2.1. Уур амьсгал	6
2.2. Газарзүйн тогтоц.....	6
2.3. Геологийн тогтоц.....	6
2.4. Хөрсөн бүрхэвч.....	7
2.5. Ургамлан нөмрөг	7
2.6. Гадаргын ус	8
2.7. Гүний ус.....	8
2.8. Амьтны аймаг.....	8
ГУРАВ. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ, ҮНЭЛГЭЭ	10
ДӨРӨВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ 2024 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ	13
ТАВ. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	14
ЗУРГАА. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	16
ДОЛОО ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	16
НАЙМ. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	17
ЕС. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР.....	18
АРАВ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	19
АРВАН НЭГ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСЭД ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	20

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт №1 Төсөл хэрэгжих талбайн байршилын координат	3
Хүснэгт №2 Төслийн байгаль орчны гол ба болзошгүй нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний нэгтгэл.....	10
Хүснэгт №3 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.....	14
Хүснэгт №4 Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө.....	16
Хүснэгт №3 Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө.....	17
Хүснэгт №7 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	18
Хүснэгт №8 Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө.....	19
Хүснэгт №9 БОМТ-ний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь	20
Хүснэгт №11 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал	21

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг № 1 Төслийн талбайн байршлын тойм зураг	3
---	---

НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1. Төслийн нэр

Богдхан уулын дархан цаазат газрын Зайсангийн аманд хэрэгжүүлж буй аялал жуулчлалын цогцолбор төслийн 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ)

1.2. Төсөл хэрэгжүүлэх аж ахуйн нэгж байгууллага

Төсөл хэрэгжүүлэгч: “Си Си энд Би Би” ХХК
Регистрийн дугаар: 5258138
Хаяг: УБ хот, Хан-Уул дүүрэг, 10-р хороо, морин 14, 590 тоот.

1.3. Төслийн байршил, тойм зураг


Тус төсөл нь Богдхан уулын дархан цаазат газрын Зайсангийн амны 3.5 га талбайд байрлаж байна. Байршлын координат тодорхойлсон баримтыг хавсралтаар оруулав.

Хүснэгт №1 Төсөл хэрэгжих талбайн байршилын координат

№	N	E	Талбайн хэмжээ, га
1	106° 54' 41.945" E	47° 52' 29.20" N	3.5 га
2	106° 54' 51.316" E	47° 52' 29.36" N	
3	106° 54' 51.832" E	47° 52' 23.20" N	
4	106° 54' 42.719" E	47° 52' 23.36" N	

Зураг №1 Төслийн талбайн байршилын тойм зураг





1.4. Төслийн төлөвлөлт

“Си си энд би би” ХХК нь Богдхан уулын ДЦГ-ын Зайсангийн аманд 3.5 га талбайг 2008 оны 9-р сарын 18-ны өдөр аялал жуулчлалын зориулалтаар ашиглах эрх авч цогцолборын барилгын ажлыг эхлүүлсэн. Одоогоор цогцолборын барилгын ажил 70%-д хүрээд байгаа бөгөөд энэ хугацаанд газар ашиглах эрхтэй холбоотой зарим маргааныг шийдвэрлэн, байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээнд нэмэлт тодотгол тайланг 2024 оны 04-р сард батлуулаад байна.

Цогцолбор нь 2 давхар нийт 32 (ширхэг) жуулчин хүлээн авах байр, сагсан бөмбөгийн талбай, ногоон байгууламж, авто машины зогсоол гэсэн барилга байгууламжуудаас бүрдэж байна.

Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд заасны дагуу жуулчин хүлээн авах байр нь аялагч, зөвшөөрөл бүхий бусад хүн түр буудаллах, отоглох зориулалттай байна.

1.5. Төсөл хэрэгжүүлэх орчны дэд бүтэц

Ус: Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын 2015 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн А/301 дугаар тушаалын 14-р хавсралтаар батлагдсан нийтийн болон ахуйн үйлчилгээний газруудын ус хэрэглээний түр нормыг үндэслэн тооцвол, төсөл хэрэгжих эхний үед хамгийн ихдээ хоногт 8100 литр буюу 8.1 м³ ус хэрэглэх бөгөөд үүний 70%-ийг бохир ус болно гэж үзвэл хоногт 5.67 м³, сард 170.1 м³ бохир ус гарах тооцоотой байна.

Аялал жуулчлалын цогцолбор нь Улаанбаатар хотын бохир усны нэгдсэн шугам сүлжээнд холбогдохоор төлөвлөөд байна.

Хатуу хог хаягдал: Төслийн талбайд нийт 235 хүн ажиллана, нэг хүн өдөрт 0.3 кг хог гаргана гэж тооцвол өдөрт 70.5 кг, улиралд 6.3 тн хог хаягдал гаргахаар байна.

ХОЁР.ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ – ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Энэхүү бүс нутаг нь Дархан цаазат газрын хязгаарлалтын бүсэд хамаарч байгаа тул байгаль орчны төлөв байдлын суурь үнэлгээг манай шинжээчдийн газар дээр нь очиж хийсэн болон Богдхан ууланд урд өмнө нь хийгдэж байсан судалгааны материалуудыг ашиглан боловсруулсан болно.

2.1. Уур амьсгал

Богдхан уул нь хүйтэн өвөлтэй, сэрүүвтэр зунтай, эх газрын эрс тэс уур амьсгалтай бүс нутагт хамаарна. Жилд дунджаар 2800 цаг нартай байдаг бол 12-14 өдөр л наргүй өдөр тохиож байдаг байна. Агаарын жилийн дундаж температур $-1.5 - 3.1^{\circ}\text{C}$, 1-р сарын дундаж хүйтэн $-19-24^{\circ}\text{C}$, 7-р сарын дундаж халуун нь $+14-17.6^{\circ}\text{C}$ хүрнэ. Уулын байрлал хотгор гүдгэрийн онцлог байрлалаас болоод газрын гадарга орчмын салхины горим ихээхэн өөр өөр байдаг. Салхины жилийн дундаж хурд 0.9-2.3 м/сек, дундаж их хурд 5 сард 1.2-4.0 м/сек, хамгийн намуун үедээ 12-1 сард 0.7-1.4 м/сек дундажтай байна. Агаарын чийгшлийн горим нэлээд өвөрмөц, агаарын чийгшил нь халуун хүйтэндээ урвуу хамааралтай байдаг. Ууланд унах хур тунадас дулааны улиралд 89.6-93.4% байна. Анхны цас 9 сарын 10 орчимд орж, сүүлчийн цас 5 сарын 20 орчимд ажиглагдана.

2.2. Газарзүйн тогтоц

Богдхан уулын Дархан цаазат газар нь Хэнтийн нурууны баруун өмнөд талын салбар уулсын нэг бөгөөд баруунаасаа зүүн тийш 31 км, хойноосоо урагш 20 км, ерөнхийдөө баруунаас зүүн тийш сунаж тогтсон хойт өргөргийн $47^{\circ}54'$ зүүн уртрагийн $106^{\circ}46'$ минутаас $107^{\circ}10'$ -ын хооронд оршино. Богдхан уулын Дархан цаазат газар нь биогеографикийн ангилал зүйн хувьд Номхон далайн ай савд хамрагддаг. Богдхан уул түүний орчим нутаг нь Хангайн Хэнтийн атриат бүсийн Хэнтийн хэсгийн баруун өмнө талд оршдог. Дархлагдсан талбайн хэмжээн чулуун нүүрсний галавын үед 350-205 сая жил хуримтлагдсан тунамал чулуулаг ба Мезозойн эриний юрийн галавийн сүүлч Цэрдийн галавын эхээр 130 сая жил үүсэж бүрэлдсэн боржин чулуу мөн уулын бэл, хормой, гуу, жалга, орчин үеийн хөвсгөр хурдас тархаж байдаг. Богдхан уулын Дархан цаазат газар нь 41.6 мянган га талбайтай. Уулын ноён оргил Цэцээ гүн далайн түвшнээс 2268 км байдаг.

Тектоник элэгдлийн хэв шинжит хотгор, гүдгэр Богдхан уулын төв хэсгийн өндөр уул, дундаж өндөр, уулсын район тектоник элэгдлийн хэв шинжит хотгор гүдгэрт морфогенетик шинжээр хамрагдана. Энэ хэв шинжийн хотгор гүдгэрийг үүсгэгч гол хүчин зүйлд тектоник өргөлт голлон, хотгор гүдгэр нь ерөнхийдөө шаталсан өндөрлөг бүхий тэгшрэлийн гадаргыг үүсгэсэн. 2000 метрээс дээш өргөгдсөн эртний тэгшрэлийн гадарга голлодог ба тэгшрэлийн гадаргын үнэмлэхүй өндөр 1800, 2000, 2200 метрийн түвшинд гурван үндсэн шатлал үүсгэсэн байна.

2.3. Геологийн тогтоц

Төсөл хэрэгжиж буй Богдхан уулын орчимд эрт төрмөлийн элсэн чулуу-занарын зузаалаг тархсан бөгөөд бүрэлдэхүүнд нь янз бүрийн мөхлөгтэй элсэн

чулуу, занар, хөрзөн чулуу, хас, кварцит, алевролит үелсэн багууд багтана. Плиоценийн давхаргадас Тасганы овоо, Заанхошуу, Шар хад, Буянт-Ухаа, Сонгино, Хонхор, Хужирбулан зэрэг газраар илрэх шохойлогдуу хөрзөн чулуу, сайран хэмхдэст, элсэрхэг наанги, сайрганцар, элсэнцэр, шавранцар, наангицараас бүрдэнэ. Зузаан 80 м. Дөрөвдөгч галавын хурдас гарал үүслийн үндсэн 6, холимог 5 төрөлд ангилагдах ба Туул голын хөндийгөөр дунд, дээд дөрөвдөгчийн аллювийн хурдас, хүрхрээгийн аманд ус-мөстлөгийн хурдас тус тус ялгагдана. Геологийн тогтцын хувьд Улаанбаатар хотын район Монгол орны геологи тектоникийн ангиллын Хэнтийн уулс хоорондын хагарлын хотгорт харьяалагдана. Районы геологийн тогтцод доод карбон, доод цэрд, неоген, дөрөвдөгчийн хурдас чулуулаг, доод мезозойн интрузив бүрдэл оролцоно.

2.4. Хөрсөн бүрхэвч

Төслийн талбай нь Монгол орны хөрс-газарзүйн мужлалын хувьд Хангайн их мужийн Хэнтийн муж 39-р тойрог буюу Хэнтийн захын тойрогт хамрагдаж байна. Хад асга бүхий тэгш орой уулын нугын хөрс, түүнээс доош ой, тайгын хөрс тогтворжиж, ой модгүй ар, өвөр хажуу болон уулын өргөн амуудад хээрийн хөрс тархана. Богд хан ууланд хамгийн их талбайг эзлэх хөрсний голлох хэв шинж нь тайгын хөрс бөгөөд түүний тархалтын нэг онцлог гэвэл уулын орой, хяр, ар хажуу түүгээр барахгүй өвөр хэсэгт нэгэн адил тархсан явдал юм. Богд уулын ноёлох өндөрлөгийн 2000 метрээс дээш орших тэгшрэлийн тавцант гадарга бүхий тагийн ландшафт зонхилсон газарт уулын нугын хөрс, уулын хавтгай орой болон чулуун асга бүхий ар хажуугийн дээд хэсгийн 1700-2000 метрийн өндөрт торлог-хөвдөт, алирс-хөвдөт хуш, гацууран ойд уулын цэвдэгт тайгын хөрс, 1600-1950 метрийн өндөрт уулын ар, өвөр, хажуугийн шинэсэн ойд уулын ширэгт тайгын хөрс тус тус тархжээ. Түүнээс гаднын хөрсний хэв шинжүүдийн шилжилт ч уулын ар, өвөр хажууд харилцан адилгүй байна. Тухайлбал уулын ар хажууд тайга, ой, хээрийн хөрс дараалан солигдож байхад уулын өвөр хажууд тайгын хөрс шууд хээрийн хөрсөнд шилжих нь түгээмэл ажиглагдана.

2.5. Ургамлан нөмрөг

Монгол орны ургамал газарзүйн мужлалаар Богд уул нь Хэнтийн уулархаг тайгын урд, Монгол-Дагуурын ойт хээрт оршдог. Ургамлын аймагт бүхэлдээ Өмнөд Сибирийн тайга, өндөр уулын элементүүд гол үүрэг гүйцэтгэнэ. Богд уулын ургамлыг бүслүүрээр хувааж үзвэл уулын хээр 28.8%, ой 52%, өндөр уул 19.3% тус тус эзэлдэг байна. Ургамалжилтын төрх байдлаар Хэнтийн нурууны салбар уулстай төстэй. Ургамлын аймагт 58 овог 230 төрөлд багтах 500-аад зүйл цэцэгт, 27 овог 42 төрөлд багтах 66 зүйл хөвд ургадаг байна. 500 зүйл цэцэгт ургамлаас 1.4% нь ойм хэлбэртэн, 1.9% нь нүцгэн үртэн, 21.6% нь нэг талт үрт, 78.4% нь хоёр талт ургамал байдаг байна. Богд хан уулын ой нь ойн бүтэн бүслүүр үүсгэхгүй, зөвхөн уулын хойт, зүүн хойт арыг барьж ургах ба ойн доод зах нь 1500-1600 м өндөрт байна. Богд хан уулын нэг онцлог нь бөмбөгөр оройтой учир оройгоороо ойттой, манай оронд ургадаг жодооноос бусад ихэнх мод, бут ургадаг. Шинжээчийн судалгаанаас үзэхэд төсөл хэрэгжих талбайд хялгана голлон ургасан ба лууль, хиаг, гичгэнэ зэрэг тархсан байна. Ургамлын бүлгэмдэл нь улалж-үетэн-алаг өвс байна.

2.6. Гадаргын ус

Ус зүйн хувьд хойд мөсөн далайн Туул голын савд багтах бөгөөд хаврын шар усны үер болон зуны хур борооны богинохон хугацаанд устай бусад үед нь тогтмол урсацтай булаг, жижиг горхи байхгүй. Туул голын урсцын тэжээлийн 69%-ийг дулааны улирлын хур тунадас бүрдүүлдэг. Туул голын сав дахь хур тунадас жилийн туршид болон дулааны улиралд нийлбэр дүнгээрээ өсөх хандлагатай ба урсац бүрдүүлэх хүчин зүйлс хэвээр хадгалагдаж байна. Энэ нь Улаанбаатар орчмын Туул голын сав дахь ургамлан бүрхэвч сийрэгжиж, хур тунадаснаас гарах гадаргын шууд урсац нэмэгдсэнтэй холбоотой гэж үзэж болох юм.

2.7. Гүний ус

Богдхан ууланд ус зүйн босоо бүслүүр илэрдэгтэй уялдаж гүний усны хэмжээ өндрөөшөө нэмэгдэнэ. Нүх сүвийн ба ан цавын ус тархсан байна. Боржин чулуулгийн өгөршлийн бүс, тектоник эвдрэлийн бүсээр ан цавын ус тархжээ. Аманд хуримтлагдсан боржин чулуун нурагт нүх сүвийн ус хуримтлагдах бөгөөд тэрээр түр зуурын /улирлын шинжтэй/ юм. Газар доорх усны урсгал нь Туул голын хөндий рүү чиглэсэн төдийд шургана. Төслийн талбай нь Туул голын сав газарт хамаарагдана. Туул голын сав газрын хэмжээнд нүх сүвийн (бүрдэл), ан цавын (бүс) гэсэн үндсэн 2 төрлийн ус агуулагч бүрдэл тархсан ба ан цав-нүх сүвийн ус болох рашаан (Улаанбаатар, Ар, Өвөр Жанчивлан зэрэг нүүрс хүчилт хүйтэн рашаан) тархсан байна. Нүх сүвэрхэг бүрдэл нь доод цэрд, неоген, дөрөвдөгчийн хурдас дотор, ан цавлаг бүс нь кембри, девон, карбоны тунамал, хувирмал, эсвэл юра, триасын түрмэл чулуулаг дотор тус тус бүрэлддэг.

2.8. Амьтны аймаг

Богд хан ууланд 54 зүйлийн хөхтөн амьтад, 200 орчим зүйлийн шувууд, 16 баг 174 овог 270 гаруй төрөлд хамаарах 1600 орчим зүйл шавж тус тус бүртгэгдээд байгаа ажээ.

Хөхтөн амьтдаас: Монгол орны хөхтөн амьтны 35 хувь буюу 6 баг, 17 овог, 40 төрөлд хамаарах 54 зүйл хөхтөн байгаагийн дотор шинээр нутагшиж буй янгир, америк усны булга ордог. Богд хан уулын 54 зүйл хөхтөн амьтадаас 13 зүйлийг ховор ховордож байгаа зүйл гэж 2008 оны Богд хан уулын улаан номд орсон. Үүнд: Дагуурын зараа *Masechinus dauricus*, Уссаг багваахай *Myotis daubentoni*, Чандага туулай *Lepus timidus*, Шар үнэг *Vulpes vulpes*, Хярс үнэг *Vulpes corsac*, ойн булга *Martes zibellina*, Хотны үен *Mustela nivalis*, Малар мануул *Otocolobus manul*, Зэрлэг гахай *Sus scrofa*, Баданга хүдэр *Moschus moschiferus*, Халиун буга *Cervus elaphus*, Бор гөрөөс *Capreolus pegargus*, Янгир ямаа *Capra sibirica* зэрэг амьтад бий.

Шувуудаас: Богд ууланд 14 багт хамаарах 36 овгийн 205 зүйлийн шувуу тэмдэглэгдсэнээс суурин 51, нүүдлийн 143 зүйл бий, нүүдлийн шувуу оршин амьдрах хэлбэрийн хувьд өндөглөн зусдаг 47, дайрч өнгөрдөг 59, хааяа тохиолдлоор орж ирдэг 5, зун тааралддаг боловч өндөглөдөг эсэх нь одоогоор тодорхойгүй 18 зүйл байдаг. Үүнээс ховор, ховордож байгаа 10 зүйл шувуу Богд хан уулын улаан номд орсон. Үүнд: Хар өрөвтас *Cickonia nigra*, Загасч явлаг *Pandion haliaetus*, Цагаан сүүл нөмрөг бүргэд *Haliaeetus albicilla*, Ооч ёл *Gypaetus*

barbatus, нургийн сойр *Tetrao parvirostris*, Шивэр хөтүү *Tetrastes bonasia*, Дагуур ятуу *Perdix dauurica*, Хар тогоруу *Grus monachus*, Бургасны ураншувуу *Remiz pendulinus*, Гацууран солбин хошуут *Loxia curvirostra* орно.

ГУРАВ. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ, ҮНЭЛГЭЭ

Хүснэгт №2 Төслийн байгаль орчны гол ба болзошгүй нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний нэгтгэл

№	БОЛЗОШГҮЙ БОЛОН ГОЛ СӨРӨГ НӨЛӨӨЛЛҮҮД	Эрчим	Үргэлжлэх хугацаа	Хамрах хүрээ	Магадлал	Нийт	Нөлөөллийн зэрэг
1. Агаарын чанарт							
1	Аялал жуулчлалын цогцолборын бүтээн байгуулалтын үед агаарт барилгын ажилтай холбоотойгоор тоосжилт үүсэх	6	1	1	5	40	Дунд
2	Цогцолборын өдөр тутмын үйл ажиллагааг хангах түүхий эдийн тээвэрлэлтийн улмаас агаарт түлшний шаталтаас үүдсэн хий ялгарах	2	4	1	5	35	Бага
2. Эдэлбэр газарт							
3	Газар ашигласны төлбөрийг цаг тухайд нь төлөхгүй байх	2	1	1	2	8	Бага
4	Барилгын ажлын явцад ахуйн ОО, бохир ус зайлуулах байгууламж болон , барилга байшингийн суурь цутгахад газрын хэвлий хөндөгдөх	8	4	1	5	65	Дунд
5	Барилгын болон үйл ажиллагааны улмаас хүн, машины хөлд эдэлбэр газар эвдрэх	6	1	1	5	40	Дунд
3. Хөрсөн бүрхэвчид							
6	Ахуйн бохир усыг газрын гадаргад их асгаснаас хөрсний ус бохирдох	6	4	1	3	33	Бага
7	Барилгын ажлын явцад хөрс талхлагдаж, морфологи бүтцэд өөрчлөлт орох	6	1	1	5	40	Дунд
8	Хог хаягдлыг цаг тухайд нь зайлуулаагүй, ил задгай хаяснаас хөрс бохирдох	8	2	1	3	33	Бага
90	Хөрсөн бүрхэвчийн ус – физик, химийн шинж чанар, геохимийн горим алдагдах	8	3	1	2	24	Бага
10	Ургамлын ургах таатай орчныг бүрдүүлэгч хөрсний ялзмагийн нөөц буурч үржил шим, бүтэц алдагдах	8	5	1	3	42	Дунд
4. Гадаргын болон газрын доорх усанд							
11	Хог хаягдлыг цаг тухайд нь зайлуулаагүй, ил задгай хаяснаас хур борооны усны урсцын нөлөөгөөр гадаргын болон газрын доорх усыг бохирдуулах	6	4	1	3	33	Бага
12	Гүний усны нөөц багассанаар тухайн орчны усны горим өөрчлөгдөх	10	5	2	2	35	Дунд

№	БОЛЗОШГУЙ БОЛОН ГОЛ СӨРӨГ НӨЛӨӨЛЛҮҮД	Эрчим	Үргэлжлэх хугацаа	Хамрах хүрээ	Магадлал	Нийт	Нөлөөллийн зэрэг
13	Гүний усаар тэжээгддэг ургамал, модод гундах	10	5	1	1	16	Бага
14	Ахуйн хатуу хог, шингэн хаягдлаар уст давхарга бохирдох	6	4	1	4	44	Дунд
5. Амьтны аймаг							
15	Цогцолборг амрах жуулчид ойд зугаалахдаа их хэмжээний дуу чимээ гаргаснаар амьтад үргэн дайжих	8	4	2	4	48	Дунд
16	Хог хаягдлаа хяналтгүй хаяснаас жижиг мэрэгч, шувуудын идэш тэжээлд нөлөөлж хордуулах зэрэг болно.	6	1	2	4	28	Бага
6. Ойн сан							
17	Ой модыг тайрснаас хөрс эвдрэн борооны усаар угаагдах	10	5	1	2	32	Бага
18	Ажилчид болон амрагчид ойд ил задгай хог хаяж бохирдуулах	6	4	1	4	44	Дунд
19	Ажилчдын санамсар болгоомжгүй байдлаас ойд гүймэр гарах	10	5	2	3	51	Дунд
20	Цогцолборын ажилчид болон жуулчид ургаа болон ногооноороо байгаа, зулзаган мод тайрах гэмтээх зэргээр ойн нөөцөд хохирол учруулах	8	4	1	4	52	Дунд
7. Ургамлан бүрхэвч							
21	Механик үйлчлэлээр /машины дугуй, хүний хөл/ талхлагдаж сийрэгжих, ургамлын нийт бүрхэц багасах	9	4	1	4	52	Дунд
22	Эвдэрч доройтсон ургамлан нөмрөгт хог ургамлын зүйлийн тоо нэмэгдэх	6	3	1	4	40	Дунд
23	Ажилчдын байр орчимд антропоген хүчин зүйлийн нөлөөгөөр ургамлан нөмрөг талхлагдах	6	4	1	4	60	Дунд
24	Барилгын ажлын явцад үүссэн тоос шороогоор даран ургамлын фотосинтезийн процесст нөлөөлөх	4	1	1	5	30	Бага
25	Ургамлан бүрхэвч гэмтэж талхлагдан, сул шороонд дарагдаж тодорхой хэмжээний доройтолд орж бүтээмж буурах	6	4	1	3	33	Бага
Нийт		6	3	1	4	38	Дунд

Шууд нөлөөлөл: Болзошгүй нөлөөллийн ихэнх нь хамрагдах бөгөөд үүний улмаас төсөл хэрэгжих орчны байгалийн унаган төрх алдагдах, ялангуяа хөрс эвдрэх, ургамлан нөмрөг талхлагдах, олон салаа зам үүсэх, хатуу хог хаягдал цуглуулах савыг ил задгай байлгах, эдгээрийг тогтмол зайлуулахгүй байх болон шингэн хаягдлын шугам хоолойд гэмтэл гарах зэргээр тохиромжгүй байдал (үнэр) үүсэх, явган зам жим олшрох зэрэг хамрагдана.

Богино хугацааны нөлөөлөл: Хог хаягдал зайлуулалт, ариутгал цэвэрлэгээ, хүн, авто тээврийн хэрэгслийн хөдөлгөөн, дуу шуугиан ихсэх, авто хөсгийн дотоод шаталтын хөдөлгүүрийн хорт хийнээс агаарын бохирдол бий болох зэрэг хамрагдаж байна.

Удаан хугацааны нөлөөлөл: Аялал жуулчлалын цогцолборын ажил болон үйлчилгээтэй холбоотойгоор хөрсний элэгдэл, эвдрэл, бохирдол, хээрийн түймэр зэрэг багтах бөгөөд эдгээр нь эргэж сэргээгдэхдээ удаан хугацаа шаардана.

Буцаж нөлөөлөх нөлөөлөл: Ахуйн хог хаягдалд зохих ариутгал хийгээгүй, хугацаанд нь зайлуулаагүй зэрэг тохиолдлоос шалтгаалж ялзарч өмхийрөн улмаар элдэв төрлийн халдварт өвчин гарч болзошгүй тохиолдлыг авч үзэж байна. Иймээс аливаа ариутгал цэвэрлэгээг энэ орчинд дор бүр нь хийж байхгүй бол ахуйн хатуу, шингэн хаягдал ихээр бохирдсоноос буцаж нөлөөлөх магадлалтай.

Буцалтгүй нөлөөлөл: Байгаль орчинтой холбоотой бүхий л үйл ажиллагааг хамруулан авч үзэж буй тул авто машины дотоод шаталтын хөдөлгүүрийн хорт хийнээс агаарын бохирдол бий болохоос бусад нь хамрагдаж байна.

Өөрөө зохицуулагдах нөлөөлөл: Авто машины дотоод шаталтын хөдөлгүүрийн хорт хийнээс агаарын бохирдол бий болох болзошгүй нөлөөллийг авч үзсэн бөгөөд энэ нь нэгд үргэлжлэх хугацаа богино, зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтрээгүй, авто машины дотоод шаталтаас гарах хорт хий болон авто машины бензин шатахууны угаар хамрагдана.

Хүчтэй нөлөөлөл: Байгалийн гэнэтийн болзошгүй осолд тооцогддог нөлөөллүүд болох газар хөдлөлт, хүчтэй салхи шуурга, анхаарал болгоомжгүйн улмаас гардаг хээрийн түймэр орох бөгөөд энэхүү нөлөөлөлд нэрвэгдсэн байгаль орчин нь нөхөн сэргээгдэхдээ удаан хугацаа шаардахын зэрэгцээгээр байгаль орчныг хамгаалах урт хугацааны төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд бэрхшээл учруулна.

Дунд зэргийн нөлөөлөл: Хөрс, хөрсний усанд бохирдуулагч бодис нэвчих, хүн ам, авто тээврийн тоо ихэссэнээс ургамал нөмрөг талхлагдах, хог хаягдлыг ариутгах, зөөж тээвэрлэх ажил удаашрах зэрэг зүйлүүд орно.

Сулавтар нөлөөлөл: Аялал жуулчлалын цогцолборын үйл ажиллагааны явцад амрагчид зохион байгуулалтгүй аялах зугаалах боломж гаргах, хөдөлгөөн, чимээ шуугиан ихсэх гэх мэт зүйлүүд орно.

ДӨРӨВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ 2024 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

Төслийг хэрэгжүүлэхдээ тухайн нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, стратегийн үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх зорилгоор 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжилтийг хангах шаардлагатай байна.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь байгаль хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрөөс бүрдэх бөгөөд байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг багасгах, арилгах арга хэмжээ, дүйцүүлэн хамгаалах хийх тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа шаардагдах хөрөнгө зардлыг тусгасан байхаар орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт төслийн үйл ажиллагааны улмаас байгаль орчны төлөв байдалд үзүүлж байгаа өөрчлөлтийг хянах, шинжилгээ хийх, үр дүнг тайлагнах, түүнийг хэрэгжүүлэх арга хэлбэр, шаардагдах хөрөнгө, зардал, хугацааг тодорхойлон тусгахаар хуульчлагдсаныг баримтлан БОМТ, ОХШХ-ийг боловсруулав.

ТАВ. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт №3 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал (төгрөг)	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрхзүйн барим бичиг
1. Агаар								
Тоосжилт, дуу шуугиан	Барилга барих явцад бэлэн бетон зуурмаг хэрэглэх, тоосжилт ихтэй үед услах Хэт чанга дуу авиа гаргахгүй байх дуу шуугианыг зөвшөөрөгдөх хэмжээнд байлгах Хог хаягдлыг ямар ч тохиолдолд шатаахыг хориглоно.	Төсөл хэрэгжих талбай	га	-	-	-	Тоосжилт үүсэх үед	Тоос, ажлын байрны агаар дахь тоосны агуулгыг хэмжихэд тавигдах ерөнхий шаардлага. MNS 5010:2001 Дуу шуугиан, шуугианы норм, аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага. MNS 5002:2000
2. Газар, хөрсний эвдрэл, бохирдол, ургамлан нөмрөг								

Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал (төгрөг)	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрхзүйн барим бичиг
Хөрс бохирдох, ургамлан нөмрөг доройтох	Цогцолборын ойр орчмыг хатуу хог хаягдлаар бохирдуулахгүй байх, үүссэн хогийг цэвэрлэж байх	Төслийн талбай	-	-	-	Үйл ажиллагааны зардалд	Жилд 1 удаа	Ариун цэврийн тухай хууль Газрын тухай хууль
	Эзэмшил газар зориулалтын дагуу үйл ажиллагаа явуулах, хил заагийг газар дээр тэмдэгжүүлэх							
Нийт								-

ЗУРГАА. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт №4 Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө

Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Ногоон байгууламж бий болгох	Эдэлбэр газрын 20 хувиас багагүй талбайд ногоон байгууламж хийх	0.04 га талбай	Ширхэг	0.04 га талбайд эгнээ хооронд 4м мод хооронд 5 м зайтай нарс тарина гэж тооцвол 10 ширхэг суулгац болохоор байна. 1 суулгац $220.000 \times 10 = 2\,200\,000\text{₮}$. мод тариагүй үлдсэн хэсгийг зүлэгжүүлнэ гэж тооцвол 1га талбайд 18 кг үр, 0.04 га талбайд 0.72 кг үр цацахаар байна. 1 кг үр 15.000₮ гэж үзвэл $(0.72 \times 15000 = 10800)$ нийт нөхөн сэргээлтийн зардал 2210800₮ болохоор байна.			Жилд 1 удаа /намар/	-

ДОЛОО ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

“Си Си Би Би” ХХК-ийн Богдхан уулын Зайсангийн аманд хэрэгжүүлж буй аялал жуулчлалын цогцолбор төслийн хүрээнд төсөл хэрэгжих талбайд түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө хийгдэхгүй. Учир нь төсөл хэрэгжих талбайд түүх соёлын өв байхгүй болно.

НАЙМ. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт №3 Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө

Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрхзүйн баримт, бичиг
Хатуу хог хаягдал	Ахуйн хог хаягдлыг богино хугацаанд зайлуулах	Төслийн талбай	-	Дүүрэгтэй гэрээ байгуулан ажиллах			Тогтмол	Хог хаягдлын тухай хууль Хог хаягдлын улсын тоо бүртгэл хөтлөх тайлагнах журам
	Хогийг хяналтгүй хаяхаас сэргийлж зурагт самбар байрлуулах		-	40 000		40 000	Тогтмол	
	Хогийг ангилан ялгах битүүмж бүхий нэгдсэн хогийн сав худалдан авах /3 ширхэг/		ш	250 000	3	750 000	Төслийн эхэнд	
Нийт				790 000				

ЕС. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Хүснэгт №7 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Хяналт шинжилгээ хийх үзүүлэлт	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Тайлбар	Баримтлах стандарт, арга аргачлал
Хөрсөн бүрхэвч	Төслийн талбай	VIII сард	Нийт 3 цэгээс зүсэлттэй агрохимийн дээж авах	20 000	60 000	Хүнд металлын агууламж Урвалын орчин Нийт азот, фосфор	MNS 5850:2019 Хөрсөнд агуулагдах хүнд металлын хэмжээ, атом шингээлтийн спектрометрийн арга
			1 цэгээс холимог дээж авах	25 000	25 000		
			Эрүүл ахуйн дээж авах	54 800	54 800		
Нийт				139 800			

**АРАВ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН
БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Хүснэгт №8 Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв	Хэрэгжүүлэх хуваарь		Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
		2024 он			
		Сар			
Болзошгүй аюул ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээний хэрэгжилтийг хангах	-	IV-XI сард		“Си Си энд Би Би” ХХК-ийн менежер	Жилд 1 удаа
Нийт		-			

**АРВАН НЭГ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ
НӨЛӨӨЛЛИЙН БҮСЭД ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ**

Хүснэгт №9 БОМТ-ний хэрэгжилтийг нөлөөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь

БОМТ, БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнах оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан, ажилтан	Зохион байгуулах газар
БОМТ-ний биелэлтийн үр дүнгийн тайланг БОУАӨЯаманд хүргүүлэх	БОМТ-ний биелэлтийн тайлан боловсруулж дүүргийн засаг захиргаанд хүргүүлнэ.	БОМТ-ний биелэлт	11 сарын 01-ны дотор хүргүүлэх	-	“Си Си энд Би Би” ХХК	-
БОУАӨЯам	Ажлын тайланг хянуулж, төлөвлөгөөг батлуулах	2025 оны БОМТ	12 сарын 01-ны дотор	-	“Си Си энд Би Би” ХХК	БОУАӨЯ

Хүснэгт №11 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал

№	Үйл ажиллагааны төлөвлөгөө	Зардал
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	-
2	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө	2 210 800
3	Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	-
4	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	790 000
5	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	139 800
5	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалтын төлөвлөгөө	
6	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсэд оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	-
	Нийт дүн	3 139 800